

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**[20 оноо]****Санамж:**

1. Эхийг анхааралтай уншин асуулт даалгавар бүрийг гүйцэтгээрэй.
2. Сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиллаарай.
3. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг дугуйлаарай.
4. Даалгавар бүр 2 оноотой.

Хуруун чинээ лааны гэрэл /өгүүллэг/

Намшир өвгөнийх Зана өвгөнийтэй хоёр гэрээр өвөлжиж байна. Өвлийн шөнийн уртыг хэлэх үү, өвгөдийн сүүжний чилэхийг хэлэх үү, бас дээр нь хоёул гэрэл гаргах лаагүйгээс тус тусын харанхуй гэрт уйтгарлан сууна. Зана өвгөнд хуруун чинээ ганц лаа үлдсэнийг Намшир зах зээлийн өвгөн гэсэндээ тандаж мэдээд өнөө үдэш тэднийд орж, өчүүхэн лааны гэрэлд хуучлав. Гэрэл гэгээ баяр баясгалан авчирдаг атал мань хоёрын яриа таарсангүй, тэгсхийгээд хэрэлдэв.

Занын шар гозойж, "Энэ муу Намшир дандаа намайг өөрөөсөө дорд үздэг. Дахиад л номчирхоод ирлээ. Би энэ муугаас юугаараа дутах юм бэ? Мадлаад өгнө өө, чамайг" гэж бодуут сүүтгэнэн асах хуруун чинээ лаандаа гэнэт харамсаад "Энэ лаа урсаж байна гэдэг чинь надаас л гарч байгаа хэрэг" гэж уурлаад лаагаа үлээчхэв. Намшир:

- Хөөе, золиг минь, Чи яаж байна аа? гэв.

- Чи ямар ном уншиж байгаа биш, цээжээр ярьж байгаа юм чинь, гэрлийн хэрэг юу байна? Харанхуйд ярь гэснээ, "Өөрөө лаагүй гуйлгачин байж, хүний лааны гэрэл бараадаж ирчхээд, бас тэгээд эзэнд нь номчирхоно гэнэ ээ? Тэгнэ байх аа, гайгүй" хэмээн харанхуйг далимдуулан шазвалзав. Намшир "Зана минь, лаагаа гамнасан болохоос миний ярианд дургүйцсэнгүй юм байна" гэж олзуурхаад:

- Чи миний саяын ярьснаас юм ойлгов уу? гэв.

- Ойлгоогүй ээ, ойлгоогүй. Ойлгоод ч яах юм бэ? гэж Зана хэдэрлэв.

- Зана минь, чи бага сургуульд ч сураагүй даанч харанхуй хүн дээ гээд харанхуйг далимдуулан өврөө суйлан сугаа маажингаа:

- Дараагийн сонгуульд ямар нам ялах бол? гэвэл,

- Ямар нь ч ялсан яадаг юм бэ? гэж зандраад Зана ууртаа чүдэнз зурав. Занын шүдгүй тулман амнаас түүний хоолойгоо тултал гударсан гаансны нь төмөр толгой дөнгөж цухуйж харагдана. Тэр бээр сахлаа хуйхлах шахам байж тамхиа асаагаад чүдэнзнийхээ модыг нясалчихсан чинь Намширын чихийг эгээ л түлчихсэнгүй, шүргээд өнгөрөв. Зана:

- Намшир минь, чи бид хоёр үхэх дөхсөн хөгшин хүмүүс. Чи яах вэ, бурхан шүтэхгүй гэж андгайлсан намын хүн байж. Харин чи өөд болсон хөгшнийхөө хойноос ганц нэг эрх маань уншихад чамд хэрэг болохгүй юм аа гэхэд өнгөрсөн тэр хөөрхийд ач болж юуны магад гэж чиний толгойд огт орохгүй юм уу? гэхэд,

- Маани шиг хэрэггүй юм хаана байна? Би маани мэгзэм уншиж мэдэх ч үгүй гэж Намшир шилбэлзлээ. Зана ууртаа гаансныхаа хүнд төмөр толгойгоор мөнгөн цохилуураа ялбийтал балбангаа:

- Чи чинь багадаа Эрдэнэзуугийн цогчин дуганы арын мөрөнд саарьтай тавхайгаа орхимжин дороосоо цухуйлгачихсан хурал хурж суугаа биз дээ? гэж цухалдав. Намшир:

- Тэр бол юм мэдэхгүй, гэнэн багын явдал. Одоо бол би бурхан шашин шиг тийм хоосон юманд хууртагдахааргүй, бүрэн болчихсон хүн гэж зориуд ам гарсан авч, яагаад ч юм, энэхэн агшинд нас барсан хайрт хань Гэрэлсүрэн нь харагдах шиг болж, дотор нь муухайрчээ. Хэсэг дуугүй суув. Эцэст нь жаахан уужирлаа. Энэ бүгд ерөөсөө Занаас л болж байгаа юм гэж Намшир хорсоод, "Энэ муу Занад бууж өгөхгүй шүү. Энэ надаар шашин шүтүүлж яах нь вэ? Бүр заавал маани уншуулах гэж хор нь буцлаад байгааг нь хараач. Сайндаа биш, намайг бүр давж авч, бах таваа хангах гэж өдөж байгаа нь энэ" гэж шазуур зуусан боловч их л талбиунаар:

- Би чамайг бурхан битгий шүт гээгүй байхад, чи намайг "шүт" гэж тулгаад л... Яах нь вэ дээ гэж өгүүлэв. Зана санаа алдсанаа:

- Тэр үнээн. Гэхдээ чи муу Гэрэлсүрэндээ насаар нь эрх бариулалгүй үхүүлсэн хүн дээ. Энэ голынхон бүгд мэднэ. Хөөрхий муу хань чинь тал харвачхаад байхдаа, чамаас нууж, маани уншиж байсныг бид цугаараа андахгүй. Чи ч их нүгэлтэй амьтан даа гэв. Намшир:

- Чи одоо нүгэл мүгэл гэж юун завхарсан юм яриад унав аа? гэж харанхуй гэрт дэмий л инээмсэглэв. Занын дуу чангарч:



- Чи бас нүгэл байхгүй гэж хуцах нь уу?...Нүгэл бий шүү ... Хулгай хийвэл нүгэл, худлаа хэлбэл нүгэл, хүн албал юу вэ?... Нүгэл биш гэж чи улих уу?... Хүн гомдоож үхүүлбэл, чиний номоор бол нүгэл бас биш үү? гэж цээжээ түхэлзтэл уухилснаа:

- Чи ерөөсөө гар... Харь... Би зулаа өргөж, мааниа уншлаа. Чиний ийм яриаг чагнаж суух надад алдас болно гээд зулаа өргөж, бурхнаасаа адис аваад шар модон эрих эргүүлж эхлэв. Намшир эзгүй, харанхуй, хүйтэн гэртээ очимгүй, зулын гэрэл жаахан бараадмаар хэдий ч одоо яая гэхэв, үүд рүү майжганав. Энэ зуур Занын эхнэр Буянхорол гаднаас орж ирээд:

- Намшир чи, бид хоёртой ханьтай жаахан сууж хуучлахгүй яагаа вэ? гэхэд:

- Зүгээрээ, харьж хэвтэе гэж хэлтэл хоолой нь чичирч орхилоо. **Хүйтэн хонгил шиг харанхуй гэрт түүний сэтгэл дааж давшгүй гунигт автаж, "Одоо ингээд нам үхээд, учир нь олдохгүй орчлонтой тооцоо дуусаж, яс амрах сан" гэж боджээ. Хүйтэн хөнжилд шургасан хойноо хайрт ханиа бүр ч үгүйлж, "Тэр минь, яагаад намайг орхиод явчхав аа?...Би түүнийг гомдоо луу?... Гомдоосон зөндөө гомдоосон. Энэ хүмүүс намайг эхнэрээ гомдоож өнгөрүүлсэн гэж ярьдаг байх нь ээ?... Өөд болсны нь дараа дэвсгэр дороос нь эрих гарсан. Тэр минь үнэхээр надаас нууж, маани мэгзэм уншдаг байж. Би ч тэгж байгаа болоо уу? гэж сэжиглэж, түүнийгээ хэлэх хэлэхгүй үгээр загнаж уйлуулж байсан. Би ч үнэхээр нүглийн тариа юм даа" хэмээн өөрийгөө үзэн ядлаа. Тэр хөнжилдөө шурган уйлахдаа Гэрэлсүрэнгийнхээ гомдлыг цайруулж чадахгүйгээс хойш, одоо амьд явж яах юм бэ? Нүгэлт намайг битгий өршөөгөөрэй ... Хохь нь" гэж өнгөнүүлэхэд халуун нулимс хүйтэн нүүр дээгүүр нь асгарлаа.**

Намшир үүрээр дугхийтэл хар дарж зүүдлээд сэрчхэв. Ганц бие өвгөн ямагт түлээ түлшээр гачигдаж байдаг тул тэр аргал түүж яваагаар зүүдэлжээ. Аргал олдохгүй болохоор айлын шаваастай аргал хулгайгаар ухаж байтал том том хөх аргал дороосоо аяндаа төмбийсөөр задарч, дундаас нь Гэрэлсүрэн нь цухуйж ирлээ. Энхрий хонгор гэргий нь гандсан хөсрий саарал тэрлэг нөмрөөд Намшираас айж, нүүр буруулна. Намшир цочиж сандарсандаа:

- Чи минь, одоо болтол төрлөө олоогүй л явна уу? гэхэд Гэрэлсүрэн,

- Би чинь иймэрхүү л янзтай явж байна шүү гэлээ. Намшир оволзсон зүрхээ "Ёо ёо" хэмээн дараад маани түргэн түргэн уншив. Тэгээд Намшир "Ерөөсөө л Занынхаас салж, амьтан хүнээс алс хол ганц гэрээрээ буугаад Гэрэлсүрэнгийнхээ хойноос зул өргөж, маани уншъя. Зөндөө уншъя. Нойр хоолгүй уншъя. Ээ халаг, хайрт хонгорыгоо амьд сэрүүн байхад сэтгэлийнх нь аяыг дагаж ямагт баярлуулж явахгүй даанч яав даа" гэж халагласнаа гэнэт үрчгэр нүүрээ харанхуйд татгануулан шүд зууж, Тэхдээ маани мэгзэм уншиж, зул өргөж байгаагаа хэнд ч мэдэгдэхгүй юм хуна даа. Ялангуяа энэ муу Занад огт сэжиг авхуулж болохгүй. За ингээд түргэн үхэх минь" гэж шийджээ.

Монгол улсын төрийн соёрхолт, соёлын гавьяат зүтгэлтэн Цэндийн Доржготов

БАГАНАН КОД
НААХ ХЭСЭГ

1. Эхэд орсон дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1. хэдэрлэх	а. хайрах шатаах
2. хуйхлах	б. далбагар болох
3. ялбийх	с. ярьж хөөрөх
4. хуучлах	д. муухай аашлах
5. түхэлзэх	е. бөмбөлзөн хөдлөх

A. 1d. 2a. 3b. 4c. 5e.

B. 1b. 2a. 3d. 4c. 5e.

C. 1d. 2e. 3b. 4c. 5a.

D. 1d. 2c. 3b. 4a. 5e.

E. 1b. 2c. 3d. 4a. 5e.

2. Хам сэдвийн хувьд бусдаас өөр хэсгийг олоорой.

A. Хөгшнийхөө хойноос ганц нэг эрих маань уншихад чамд хэрэг болохгүй юм аа гэхэд өнгөрсөн тэр хөөрхийд ач болж юуны магад гэж чиний толгойд огт орохгүй юм уу?

B. Зана минь, чи бага сургуульд ч сураагүй даанч харанхуй хүн дээ гээд харанхуйг далимдуулан өврөө суйлан сугаа маажингаа:

C. Чи бас нүгэл байхгүй гэж хуцах нь уу?...Нүгэл бий шүү ... Хулгай хийвэл нүгэл, худлаа хэлбэл нүгэл, хүн албал юу вэ?... Нүгэл биш гэж чи улих уу?...

D. Чи чинь багадаа Эрдэнэзуугийн цогчин дуганы арын мөрөнд саарьтай тавхайгаа орхимжин дороосоо цухуйлгачихсан хурал хурж суугаа биз дээ?

E. Тэр үнээн. Гэхдээ чи муу Гэрэлсүрэндээ насаар нь эрих бариулалгүй үхүүлсэн хүн дээ. Энэ голынхон бүгд мэднэ.

3. Тодруулсан хэсгийн хэв маягийг тодорхойлоорой.

- A. Болоод өнгөрсөн үйл явдлыг хүүрнэсэн тул хүүрнэмж
- B. Өнгөрсөн байдлыг нэг бүрчлэн тоочин дүрсэлсэн учир тоочимж
- C. Үйл явдал хэрхэн болж байсныг тайлбарласан тул тайлбарламж
- D. Өөрийн өнгөрснийг дүгнэж эргэцүүлж байгаа тул эргэцүүлэмж
- E. Ямар хүн байснаа нэг бүрчлэн тоочин бодож байгаа тул тоочимж, эргэцүүлэмж хосолсон

4. Өгүүллэгийн “Өвлийн шөнийн уртыг хэлэх үү, өвгөдийн сүүжний чилэхийг хэлэх үү, бас дээр нь хоёул гэрэл гаргах лаагүйгээс тус тусын харанхуй гэрт уйтгарлан сууна” тодруулсан хэсэгт аль дүрслэх ур маягийг ашигласан байна вэ?

- A. адилтгал
- B. хэтрүүлэл
- C. тойруулал
- D. багасгал
- E. харшуулал

5. Өгүүллэгт “хуруун чинээ лааны гэрэл”-ээр юуг төлөөлүүлсэн байна вэ?

- A. Хөх аргалаас аяндаа төмбийсөөр задарч, дундаас нь Гэрэлсүрэн нь цухуйж байгаа зүүдийг
- B. Мэгзэм уншиж, зул өргөж байгаагаа хэнд ч мэдэгдэхгүй юм хуна гэсэн санааг
- C. Гэрэлсүрэнгийнхээ хойноос зул өргөж, маани уншъя гэсэн ухаарлыг
- D. Зана өвгөнийхөөс салж нүүж байж л маань унших юм шүү гэсэн бодлыг
- E. Нам засаг дагаж эрдэм ном хөөснөөр багахан ч гэсэн гэгээрч чадсан гэгээрлийг

6. Өгүүллэгийн “Чи чинь багадаа Эрдэнэзуугийн цогчин дуганы арын мөрөнд саарьтай тавхайгаа орхимжин доороосоо цухуйлгачихсан хурал хурж суугаа биз дээ” хэсгээр Занын сэтгэлийн ямар өнгө аяс илэрч байна вэ?

- A. уурлаж гоморхсон
- B. харуусаж гунигласан
- C. гайхаж тээнэгэлзсэн
- D. эгдүүцэж хорссон
- E. асууж лавшруулсан

7. Өгүүллэгийн үйл явдал “Намшир эзгүй, харанхуй, хүйтэн гэртээ очимгүй зулын гэрэл жаахан бараадмаар хэдий ч одоо яая гэхэв, үүд рүү майжганав” гэжээ. Намширыг ийм байдалд хүрэх нь ямар нөхцөлөөс эхэлсэн бэ?

- A. Сахлаа хуйхлах шахам байж тамхиа асаагаад чүдэнзнийхээ модыг нясалчихсан чинь Намширын чихийг эгээ л түлчихсэнгүй, шүргээд өнгөрөв.
- B. Чи одоо нүгэл мүгэл гэж юун завхарсан юм яриад унав аа? гэж харанхуй гэрт дэмий л инээмсэглэв.
- C. Намшир "Зана минь, лаагаа гамнасан болохоос миний ярианд дургүйцсэнгүй юм байна" гэж олзуурхаад: -Чи миний саяын ярьснаас юм ойлгов уу? гэв.
- D. "Энэ лаа урсаж байна гэдэг чинь надаас л гарз гарч байгаа хэрэг" гэж уурлаад лаагаа үлээчхэв.
- E. Гэрэл гэгээ баяр баясгалан авчирдаг атал мань хоёрын яриа таарсангүй, тэгсхийгээд хэрэлдэв.

8. Өгүүллэгийн “Зана”-ын дүрд тохирохыг сонгоорой.

- A. Тэр бол үйлдсэн нүгэл ихтэй түүнийгээ цагаатгаж маань мэгзэм уншсан хүн
- B. Тэр бол бол хуурмаг зүйлд дургүй, өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй хүн
- C. Тэр бол үхэхээ хүлээхээс өөр хийж чадах зүйлгүй болсон ядарсан хөгшин хүн
- D. Тэр бол нам, сонгууль мэтийн дэмий ярианд дургүй бурхан шүтлэгтэй хүн
- E. Тэр бол Намширт мэдлуулсандаа хорсож үгээр идсэн хорон санаат хүн

9. Зана, Намширт учир зүггүй уурлах болсон шалтгаан юу вэ?

- A. Намшир өөрийн өнгөрснийг юм мэдэхгүй багынх явдал гэж үгүйсгэсэн нь
- B. Намшир өөртөө ганц ширхэг лаагүй байж лаанаас нь хороолцсон нь
- C. Намшир нүгэлгүй, нүгэл гэж байхгүй гэж зөрж зүтгэж, бас сонгууль ярьсан нь
- D. Намшир муу эхнэртээ ч маань уншуулалгүй хэцүүхэн байлгаж үхүүлсэн нь
- E. Намшир өөрийгөө эрдэм номтой бүрэн болсон хүн гэж дөвийлгөсөн нь



10. Өгүүллэгийн гол санааг илэрхийлсэн хэсэг аль нь вэ?

- A. "Ёо ёо" хэмээн дараад маани түргэн түргэн уншив. За ингээд түргэн үхэх минь" гэж шийджээ.
- B. Тэхдээ маани мэгзэм уншиж, зул өргөж байгаагаа хэнд ч мэдэгдэхгүй юм хуна даа. Ялангуяа энэ муу Занад огт сэжиг авхуулж болохгүй.
- C. "Ерөөсөө л Занынхаас салж, амьтан хүнээс алс хол ганц гэрээрээ буугаад Гэрэлсүрэнгийнхээ хойноос зул өргөж, маани уншъя. Зөндөө уншъя. Нойр хоолгүй уншъя.
- D. Чи минь, одоо болтол төрлөө олоогүй л явна уу? гэхэд Гэрэлсүрэн, -Би чинь иймэрхүү л янзтай явж байна шүү гэлээ.
- E. Хайрт хонгорыгоо амьд сэрүүн байхад сэтгэлийнх нь аяыг дагаж ямагт баярлуулж явахгүй даанч яав даа" гэж халагласнаа гэнэт үрчгэр нүүрээ харанхуйд татгануулан шүд зүүв.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

[30 0100]

Санамж:

- Даалгавар тус бүрийн зааврыг анхааралтай уншиж гүйцэтгээрэй.
- Даалгаврын хариуг шалгалтын дэвтрийн зохих зайд бичиж тэмдэглээрэй.
- Даалгавар бүрийн оноо харилцан адилгүй болно.

2.1. Дараах шүлгийг уншин зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай үгийг олж зөв болгон зассан тохиолдол тус бүр 1 оноо [5 оноо]

Нар зөвийн эх орон

Амьдралын жирийн нэг өглөө байтал уярал догдлол төрж

Алтан дэлхийд амьд явахын үнэ цэнийг мэдрүүлж

Айлын гэрийн өрхний оосрыг нар зөв даллаад

Арван наймтай бүсгүй гэргий болдог Эх орон

Нар зөвийн эх орон Миний Монгол

Тэнгэрийн заадасыг өгсөж, уруудан галгих хоёр морин од

Тэмдэгрэх үүрийн зүүдэд нь ер бусын мэдрэмж илгээхэд

Сүүмийх алсын амьдрал зорьж, сэтгэлдээ ган хэт цахиад

Сүлд өөдөө зормиг хөвгүүд бүсээ зөв ороогоод эр болдог Эх орон

Нар зөвийн эх орон Миний Монгол

Эгшиг уянгын хорвоод хайрын зөрөг дээр харц учраад

Энгэр дүүрэн жаргал тээж, биедээ тэмүүлэх залуус

Өр зүрхний гүндээ амраг нарны гал зангидаж

Өнө эртнийн шаргал талд ханаа зөв дугуйлаад айл болдог Эх орон

Нар зөвийн эх орон Миний Монгол

Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн А.Эрдэнэ-Очир

Алдаатай бичсэн үг
Засаж бичсэн үг

2.2. Дараах цогцолборыг уншаад кирилл бичигт хөрвүүлээрэй.

[5 0100]

0-1 алдвал 5 оноо, 2-3 алдвал 4 оноо, 4-5 алдвал 3 оноо, 6-7 алдвал 2 оноо, 8-9 алдвал 1 оноо, 10-с дээш алдвал 0 оноотой болно.

[illegible]

Түүний тулд хэрхэн буйгаа “**Миний мөрөөдөл**” сэдвийн дор сийрүүлэн бичнэ үү.

Бичгийн соёл оноонд нөлөөлөхийг анхаарна уу.

/Үгийн тоо 200-250/

[20 очоо]



Даалгавар	Зөв бичих чадвар	Үндэсний бичгээр унших чадвар	Эх зохион найруулах чадвар							
			Сэдэв ба зорилго	Бүтэц	Эшлэл баримт	Бичлэгийн хэлбэр төрөл	Хэл зүй, найруулга	Үгийн тоо	Зөв бичгийн дүрэм	Бичгийн соёл
Авбал зохих оноо	5	5	5	3	2	2	3	1	3	1
Авсан оноо										

Дүгнэж оноожуулсан багшийн код

